



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/185

Номгон


Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор малын сэг, зэм устгалын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “а” дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн “Хаваржилтын болзошгүй хүндрэл, хүн малын халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж, хорогдсон малын сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэх, отор, нүүдлийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих тухай” 01 тоот албан даалгаврыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын сэг, зэм устгах ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор малын сэг, зэм устгалын ажлыг 03 дугаар сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулж үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнахыг сумдын Засаг дарга нарт, ажлын чанар гүйцэтгэлийг хангуулж Онцгой комисст тайлагнахыг Мал эмнэлгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН.

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/185 дугаар захирамжийн хавсралт



МАЛЫН СЭГ, ЗЭМ УСТГАХ АЖЛЫН НЭГДСЭН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Зорилго нь: Хүнс, хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 тоот албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/47 тоот тушаал, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 онд баталсан Мал, амьтны хүүр, сэг, зэм, устгах үйл ажиллагааны зааврыг бүх шатанд мөрдөж ажиллахын хүрээнд хүн, малын халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор малын сэг зэгийг устгах, бэлчээр бууц, хашаа байр, уст цэг, усны эх булгийг цэвэрлэж, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах, мөн түүхий эд, боловсруулах цэг, мах болон хүнсний ногооны зоорь, агуулах, контейнер, Мазаалай хүүхдийн парк, Жаргалант паркуудад ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэхэд оршино. Үүний үр дүнд:

1. Бэлчээрийн бохирдол багасна
2. Эрүүл орчинг бүрдүүлнэ
3. Нийтийн эрүүл мэндийг хамгаална
4. Өвөлжөө бууцны шимэгч устана
5. Малын халдварт өвчний гаралт, тархалтаас урьдчилан сэргийлнэ.

Хоёр. Хамрах хүрээ, хугацаа

Баянхонгор аймгийн 20 сумын 104 багийг хамарч 2020 оны 03 дугаар сарын 10-наас 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулна.

Гурав. Зохион байгуулалт

Сумдын Засаг дарга нар ажлын хэсэг байгуулж дээрх ажлыг зохион байгуулсан талаарх тайланг сар бүрийн 5-нд Мал эмнэлгийн газарт тайлагнана.

Аймгийн Мал эмнэлгийн газар хагас жилийн тайлан мэдээг 2020 оны 07 дугаар сарын 01-ний дотор, бүтэн жилийн тайланг 10 дугаар сарын 01-ний дотор багтаан Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс болон аймгийн Засаг даргад тайлагнана.

2.

Хамтран хэрэгжүүлэх байгууллагууд:

- Аймгийн Мал эмнэлгийн газар
- Сумдын Засаг даргын Тамгын газар
- Сумдын Мал эмнэлгийн тасаг
- Хувийн хэвшлийн аж ахуй нэгж
- Хөдөө аж ахуйн тасаг хамтран зохион байгуулна.

Эдгээр байгууллага нь аяны зохион байгуулалт, үр дүн, сэг зэмийн устгал, ариутгал, халдваргүйтгэл, Өвөлжөө бууцыг сийлж овоолж байгаа талаар цаг тухай бүр Мал эмнэлгийн газарт мэдээлнэ.

Дөрөв. Зохион байгуулж гүйцэтгэх ажил, арга хэмжээ

- Халдваргүйтгэл хийх ажлын ач холбогдлын талаар малчид, мал бүхий иргэдэд мэдээлэл сурталчилгаа хийж Засаг даргын захирамжаар ажлын хэсэг, явах маршрутыг батлуулж, тогтоосон хугацаанд чанартай хийж гүйцэтгэх

-Малын хүүр, сэг зэмийг өвөлжөө, хаваржаа, хашаа хорооноос 500 метрээс доошгүй зайтай газарт автомашин, үерийн ус, зам, худаг уст цэгээс зайдуу газарт нохой болон жижиг махчин амьтан ухаж идэхээргүйгээр нүх ухаж булах буюу шатааж устгах

-Малын хашаа хорооны өтөг бууцыг сийлж овоолон, биотермийн аргаар халдваргүйтгэх

-Малын сэг, зэм тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг цэвэрлэж, халдваргүйтгэх

-Булаг, шандны эхийг цэвэрлэж, тойруулан хашиж, малын ялгадас, бордоо, цасны ус орохоос хамгаалсан суваг, шуудуу татах арга хэмжээ авахуулах

-Цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийн ажлын талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт, семинар зохион байгуулах, гарын авлагаар хангах

- Мал, амьтны хүүр сэг зэмийг устгах халдваргүйтгэх ажлыг гүйцэтгэхдээ хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч гарын үсэг зуруулах

-Ариун цэвэр халдваргүйтгэлийн ажлын явц, хэрэгжилтэд Мал эмнэлгийн газар, сумын Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч хяналт тавьж илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах

-Улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, чанар стандартын шаардлага хангасан, хүн, малын эрүүл мэнд, байгаль экологид хор нөлөөгүй, ариутгал халдваргүйтгэлийн бодис, бэлдмэлийн нөөцийг орон нутагтаа бүрдүүлэх

-Ариутгал халдваргүйтгэлийн бодисын хэрэглээ, чанар, үр дүнд хяналт тавих /Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч/

-Мал төхөөрөх үйлдвэр, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн хадгалах, худалдаалах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг зах, худалдааны төвүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, мал эмнэлгийн шаардлагыг мөрдүүлэх, ариутгал халдваргүйтгэл хийх

-Гахай, тахианы фермер эрхэлдэг иргэн аж, ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах /орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийх/

- Мал, амьтны сэг, зэмийг устгах, орчны халдваргүйтгэл хийх ажилд оролцогч талуудын хамтын ажиллагаа, үүрэг, оролцоог тодорхой болгож, тухайн сумын Засаг даргын захирамжид тусгуулж ажиллах

-Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сургалт, сурталчилгааг тогтмол хийх, сэг, зэм устгах орчны халдваргүйтгэлийн ач холбогдлыг таниулах,

-Сэг зэм устгах, орчны цэвэрлэгээ ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг сум, багийн хэмжээнд хэрхэн зохион байгуулсан, бэлчээрийн эрүүл ахуйн ариун цэвэр хангасан эсэх, сум орон нутгаас зарцуулсан зардал, үр дүнг зэргийг тооцон тайлагнах

Тав. Бусад

5.1. Сэг зэм устгал, ариутгал халдваргүйтгэлийн ажлын мэдээг хавсралт маягтын дагуу долоо хоног бүрийн баасан гарагийн 13 цагаас өмнө аймгийн Мал эмнэлгийн газрын Шимэгчтэх халдваргүй өвчин, биобэлдмэл, хэрэглээний эмийн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Батцэцэгт Battsetseg9494@gmail.com хаягаар ирүүлнэ. Дэлгэрэнгүй тайланг сар бүрийн 05-ны дотор Мал эмнэлгийн газарт ирүүлнэ.

_____оОо_____